# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2024/16/НА-СТА-ТТЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Хөвсгөл аймаг<br>2024 он | Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Б.Даваанямм<br>Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг 67120
Утас/факс 7038 3793, Цахим шуудан khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас www.audit.mn

2024.03.25 № 01/266

танай ____________-ны № ____________-т

ТӨМӨРБУЛАГ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ЭНХБАЯР ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчилтэй зүйл илэрлээ. ***Үүнд:***

- Өмнөх аудитаар өгсөн орон нутгийн орлогын төлөвлөгөө бүрэн биелүүлж ажиллах албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.
- Сумын орон нутгийн орлогыг 124.6 сая төгрөгөөр тасалсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд "Эрх үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд ТТЗийн хяналтад байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 40.9 сая төгрөгийн хөрөнгө, шилжүүлэн авсан 112.4 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 14.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 22.1 сая төгрөгийн зам гүүрний байгууламж, 127.0 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг хөрөнгийг тус тус бүртгэж үндсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 9 иргэнтэй холбоотой 28.0 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь 157.0 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 5.4 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх

572404О566

орлогыг 2.7 сая төгрөгөөр тус тус тасалсан бөгөөд төсвийн тухай хуульд заасан үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төмөрбулаг сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 92.8 хувьтай биелүүлж ажилласан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 542,976.1 | 401,396.7 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 3а, 3б | 295,867.0 | 174,647.8 |
| 33 | АВЛАГА | 5а, 5б, 6а, 6б | 96,184.3 | 72,700.3 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8а, 8б, 8в | 150,924.8 | 154,048.6 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 998,375.8 | 1,358,356.4 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 11а, 11б | 16,000.0 | 174,500.0 |
| 37300 | Урт хугацаат зээл | | 16,000.0 | 174,500.0 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 12а, 12б, 12в | 982,375.8 | 1,183,856.4 |
| 39200 | Биет хөрөнгө | | 953,039.6 | 1,155,210.1 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 13 | 29,336.3 | 28,646.3 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | | 1,541,351.9 | 1,759,753.1 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | 3,642.2 | 6,921.7 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 15а, 15б | 3,642.2 | 6,921.7 |
| 41300 | Өглөг | 17а, 17б | 3,642.2 | 6,921.7 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 1,537,709.7 | 1,752,831.4 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 1,537,709.7 | 1,752,831.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | | 416,511.2 | 416,511.2 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 1,001,844.9 | 1,268,094.5 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 119,353.6 | 68,225.7 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | | 1,541,351.9 | 1,759,753.1 |

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тодруулга | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | | 1,275,877.3 | 1,707,681.7 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | 285,849.5 | 353,542.9 |
| 110 | Орлогын албан татвар | | 182,921.4 | 221,452.4 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | | 193,366.2 | 231,826.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | | -10,444.9 | -10,373.6 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | | 41,514.6 | 70,187.6 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | | 61,413.5 | 61,903.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1а, 1б | 53,848.4 | 174,636.2 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 53,848.4 | 174,636.2 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | | 936,179.3 | 1,179,502.6 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2а, 2б | 1,169,080.2 | 1,458,963.8 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 1,169,080.2 | 1,458,963.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 1,112,268.6 | 850,929.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 380,565.8 | 516,068.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 48,590.7 | 65,295.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | | 464,880.0 | 37,417.2 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 45,416.5 | 68,650.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 12,883.6 | 9,944.2 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 1,560.0 | 2,249.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 44,159.1 | 24,205.7 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 114,212.8 | 127,097.3 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 56,811.6 | 608,034.7 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | | 106,797.1 | 248,717.9 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | 7,115,528.8 | 32,987.0 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | | -7,008,731.7 | 215,730.9 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2022оны 12-р сарын 31 | 2023 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,290,903.8 | 1,574,377.3 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 285,849.5 | 353,542.9 |
| 110 | Орлогын албан татвар | 182,921.4 | 221,452.4 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 193,366.2 | 231,826.0 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -10,444.9 | -10,373.6 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 41,514.6 | 70,187.6 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 61,413.5 | 61,903.0 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 6,265.6 | 11,148.4 |
| 1181 | Газрын төлбөр | 1,154.1 | 1,964.6 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 53,993.9 | 48,790.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 68,875.0 | 39,455.7 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 68,875.0 | 39,455.7 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 936,179.3 | 1,181,378.7 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,241,602.0 | 1,494,684.6 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,241,602.0 | 1,494,684.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 999,329.6 | 1,224,175.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 380,565.8 | 514,241.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,755.6 | 65,068.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 464,757.3 | 37,318.1 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 30,872.7 | 37,824.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 14,872.2 | 14,047.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,560.0 | 2,249.6 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 23,979.0 | 526,994.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,967.1 | 26,432.2 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 242,272.4 | 270,509.2 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 49,301.8 | 79,692.7 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 8,070.0 | 40,912.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 8,070.0 | 40,912.0 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 8,070.0 | 40,912.0 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -8,070.0 | -40,912.0 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 0.0 | -160,000.0 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 0.0 | 160,000.0 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 41,231.8 | -121,219.3 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 254,635.2 | 295,867.0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 295,867.0 | 174,647.8 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Өөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 8,578,932.9 | 0.0 | 8,578,932.9 |
| 10 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,537,709.7 | 0.0 | 1,537,709.7 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,546,441.4 | 0.0 | 8,546,441.4 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -32,491.5 | 0.0 | -32,491.5 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | -7,008,731.7 | 0.0 | -7,008,731.7 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,537,709.7 | 0.0 | 1,537,709.7 |
| 20 | 2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 1,752,831.4 | 0.0 | 1,752,831.4 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,588,228.4 | 0.0 | 1,588,228.4 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 50,518.6 | 0.0 | 50,518.6 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -51,127.9 | 0.0 | -51,127.9 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 215,730.9 | 0.0 | 215,730.9 |

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Гүйцэтгэл зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,986,020.6 | 1,654,338.6 | 331,682.0 | 83.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,771,470.6 | 1,494,338.6 | 277,132.0 | 84.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,285,108.3 | 1,232,720.7 | 52,387.6 | 95.9 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 533,782.9 | 514,241.0 | 19,541.9 | 96.3 |
| 210101 | Үндсэн цалин | 350,490.8 | 353,595.7 | -3,104.9 | 100.9 |
| 210102 | Нэмэгдэл | 138,274.9 | 127,753.6 | 10,521.3 | 92.4 |
| 210104 | Урамшуулал | 45,017.2 | 32,891.6 | 12,125.6 | 73.1 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 67,106.7 | 65,068.6 | 2,038.1 | 97.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,083.9 | 44,418.2 | 665.7 | 98.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,992.7 | 5,154.6 | 838.1 | 86.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,274.6 | 4,132.7 | 141.9 | 96.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,068.8 | 1,030.3 | 38.5 | 96.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,686.7 | 10,332.8 | 353.9 | 96.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 516,607.2 | 506,084.5 | 10,522.7 | 98.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,979.0 | 21,413.3 | 5,565.7 | 79.4 |
| 210302 | Түлш, халаалт | 481,828.2 | 481,083.2 | 745.0 | 99.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,800.0 | 3,588.0 | 4,212.0 | 46.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 38,770.0 | 34,712.8 | 4,057.2 | 89.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,400.0 | 6,359.5 | 40.5 | 99.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,540.0 | 18,514.3 | 25.7 | 99.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,000.0 | 5,947.4 | 1,052.6 | 85.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 500.0 | 0.0 | 500.0 | 0.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,750.0 | 200.0 | 1,550.0 | 11.4 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,580.0 | 3,691.6 | 888.4 | 80.6 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 79,411.1 | 73,225.0 | 6,186.1 | 92.2 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 21,600.0 | 21,600.0 | 0.0 | 100.0 |
| 210602 | Тавилга | 1,680.0 | 1,680.0 | 0.0 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 56,131.1 | 49,945.0 | 6,186.1 | 89.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,960.0 | 2,249.6 | 710.4 | 76.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,960.0 | 2,249.6 | 710.4 | 76.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,731.4 | 29,318.0 | 4,413.4 | 86.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 31,182.2 | 27,825.6 | 3,356.6 | 89.2 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 600.0 | 54.5 | 545.6 | 9.1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250.0 | 132.0 | 118.0 | 52.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 129.2 | 0.0 | 129.2 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,250.0 | 986.0 | 264.0 | 78.9 |
| 210807 | Газрын төлбөр | 320.0 | 320.0 | 0.0 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,739.0 | 7,821.3 | 4,917.7 | 61.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,900.0 | 6,435.3 | 4,464.7 | 59.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,839.0 | 1,386.0 | 453.0 | 75.4 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 486,362.3 | 261,617.8 | 224,744.5 | 53.8 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 484,607.3 | 259,988.8 | 224,618.5 | 53.6 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 484,607.3 | 259,988.8 | 224,618.5 | 53.6 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,755.0 | 1,629.0 | 126.0 | 92.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,755.0 | 1,629.0 | 126.0 | 92.8 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 214,550.0 | 160,000.0 | 54,550.0 | 74.6 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 214,550.0 | 160,000.0 | 54,550.0 | 74.6 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,986,020.6 | 1,537,258.8 | 448,761.8 | 77.4 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 214,531.0 | 206,531.0 | 8,000.0 | 96.3 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 214,531.0 | 206,531.0 | 8,000.0 | 96.3 |
| 32 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,411,089.6 | 1,298,382.5 | 112,707.1 | 92.0 |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 1,411,089.6 | 1,298,382.5 | 112,707.1 | 92.0 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 360,400.0 | 32,345.2 | 328,054.8 | 9.0 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 61,000.0 | 28,209.9 | 32,790.1 | 46.2 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,000.0 | 4,135.3 | 2,864.7 | 59.1 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 292,400.0 | 0.0 | 292,400.0 | 0.0 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 208,894.9 | -208,894.9 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 91,815.1 | -91,815.1 | |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | 55 | 55 | 0 | 100.0 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | 0 | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | 0 | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 27 | 27 | 0 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 9 | 9 | 0 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12 | 12 | 0 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 | 0 | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 27 | 27 | 0 | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 12 | 12 | 0 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 6 | 6 | 0 | 100.0 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 9 | 9 | 0 | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 40,878.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 40,878.29 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 30,490.55 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 3,111.40 |
| 210401 | Бичиг хэрэг | 50.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,561.40 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,322.00 |
| 210602 | Тавилга | 2,090.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,232.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,322.35 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,322.35 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,734.80 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,734.80 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,387.74 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 740.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 740.00 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,647.74 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 9,647.74 |
| I | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 40,878.29 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 40,878.29 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,020.85 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 34,357.44 |

## АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого, болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 254.4 сая төгрөгийн 2 алдаа, 8.1 сая төгрөгийн 5 зөрчил илэрсэн. Аудитын явцад 254.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 8.1 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн байна.

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 194.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс 165.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгч 29.8 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмжийг өгсөн.

Төмөрбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь сумын орон нутгийн орлогыг 124.6 сая төгрөгөөр тасалсан зөрчлийг материаллаг зөрчилд тооцсон бөгөөд тогтоосон материаллаг түвшнээс 108.8 сая төгрөгөөр давсан тул хязгаарлалттай дүгнэлт өгөөр шийдвэрлэсэн.

### 5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй, сумын орон нутгийн орлогыг 124.6 сая төгрөгөөр тасалсан.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Үйл ажиллагааны орлого 1.2 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 5.3 сая төгрөгөөр, бууны албан татварын орлого 0.6 сая төгрөгөөр, малд ногдуулах албан татварын орлого 146.1 сая төгрөгөөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого нийт 1.8 сая төгрөгөөр, дуудлага худалдааны орлого 2.0 сая төгрөгөөр, нийт 124.66 сая төгрөгөөр тасарсан.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 4.5 сая төгрөг, Газрын дуудлага худалдааны орлогыг 0.9 сая төгрөг нийт 5.4 сая төгрөгөөр тасалсан.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл: Аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогыг 1.1 сая төгрөгөөр, дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлогыг 1.6 сая төгрөгөөр нийт 2.7 сая төгрөгөөр тасалсан байна.

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь нийт 165.0 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байгаа бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар**

1.1. <u>Илрүүлэлт:</u>

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 14 иргэнтэй холбоотой 29.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021оны 361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд Эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй

1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Харьяа байгууллагуудын алдаа | | | | | | | | | | |
| Төмөрбулаг сумын ЗДТГ | **2** | **254,350.8** | **1** | **149,300.7** | **1** | **105,050.1** | **2** | **254,350.8** | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Орлого бүрдүүлэлттэй холбоотой | 1 | 165,000.0 | | | 1 | 165,000.0 | | |
| Хугацаа хэтэрсэн зээлийн авлага | 1 | 29,800.0 | | | | | 1 | 29,800.0 |
| **Дүн** | **2** | **194,800.0** | | | **1** | **165,000.0** | **1** | 29,800.0 |
| Харьяа байгууллагуудын зөрчил /ЗДТГ/ | | | | | | | | |
| Өр, авлага үүсгэсэн | 1 | 5,563.1 | | | | | 1 | 5,563.1 |
| Байгууллагын санхүүгийн тайланг 2024.01.25-ны өдөр гарын үсэг тамга тэмдгээр баталгаажуулаагүй, тодруулга толилуулгагүй ирүүлсэн | 1 | | | | | | 1 | |
| Байгууллагын төсвөөс төрийн албан хаагчдын тэмцээнд оролцсон тамирчдын буудлын зардалд 440.0 мянган төгрөг, хоолны зардалд 2,130.0 мянган төгрөг, нийт 2,570.0 мянган төгрөгийг зарцуулсан | 1 | 2,570.0 | 1 | 2,570.0 | | | | |
| | **3** | **8,133.1** | **1** | **2,570.0** | | | **2** | **5,563.1** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Харьяа байгууллагуудын зөрчил | | | | | | | | |
| Байгууллагын газрын үнэлгээ, бичиг баримттай холбоотой | 2 | | | | | | 2 | |
| **Дүн** | **2** | | | | | | **2** | |

### Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 2 | 1 | 1 | | 1 | | | |
| 2 | Төсөл, хөтөлбөр | 2 | | 2 | | | | | |
| 3 | ТТЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **5** | **2** | **3** | | **1** | **1** | | |